

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

*Нийтийн албан тушаалтны хууль бус
хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх,
нөхөн төлүүлэх тухай хуулийн төсөл болон
туүнийг дагалдуулан боловсруулсан
бусад хуулийн төслийн талаар*

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хуулийг дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж хуульчлан төрийн үйл ажиллагааны нийтээр дагаж мөрдөх суурь зарчим болон авлигаас ангид байх төрийн бодлогын эрх зүйн үндсийг тодорхойлж, түүнчлэн Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “иргэн нь хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжуулах эрхтэй.” гэж хуульчлан иргэн өмчийн эрхээ шударгаар хэрэгжүүлэх суурь зарчмыг тунхаглан баталгаажуулсан байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)” зэрэг төрийн бодлогын баримт бичгүүдэд Монгол Улсад авлигагүй нийгмийг цогцлоон бүрдүүлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, боловсронгуй болгох, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн нас барсан, сураггүй алга болсон, оргон зайлснаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж, улсын орлого болгох тогтолцоог бий болгоо тус тус заасан.

Монгол Улсад авлигын эсрэг чиглэсэн хуулиуд мөрдөгдөж байгаа хэдий ч бодит үр дүн гаргах тал дээр хүндрэлтэй байгааг олон улсын судалгаанууд илэрхийлсээр байна. Тухайлбал, Монгол Улс “Транспэрэнси Интернэшнл” олон улсын байгууллагын 2023 оны Авлигын төсөөллийн индексээр манай улс 180 улсаас 2018 онд **93**, 2019 онд **106**, 2020 онд **111**, 2021 онд **110**-т эрэмбэлэгдэж байсан бол 2022 онд 6 байраар ухарч **116**-д, 2023 онд өмнөхөө оны эрэмбээс 5 байраар ухарч **121**-д эрэмбэлэгдсэн байна.

Энэхүү авлигын төсөөллийн индекс нь манай улсын авлигын түвшинд өгч буй олон улсын байгууллагын үнэлгээ бөгөөд Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийн төслийг боловсруулан батлуулах нь үнэлгээнд ахиц гаргах нэг алхам болох юм.

Улс төрд нөлөө бүхий этгээд, төрийн албан тушаалтнууд эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгох нь даамжирч, иргэдийн боломжийг хязгаарлан, эдийн засаг, нийгэм, боловсрол, эрүүл мэнд зэрэг бүхий л салбарт тэгш бус байдлыг үүсгээд байна. Энэ нь улс орны эрсдэлийг нэмэгдүүлэн олон улсын байгууллагуудын үнэлгээнд муугаар нөлөөлж, улмаар иргэдийн төрд итгэх итгэлийг бууруулахад хүргэж байна.

Авлига, мөнгө угаах гэмт хэргийн шинжийг оновчтой тодорхойлоогүй байдал, нийтийн албан тушаалтны гэмт хэрэг үйлдэж олсон болон хууль бусаар

олсон хөрөнгө, орлогыг хураан авах, хураан авсан хөрөнгө, орлогыг хадгалах, захиран зарцуулах, захиран зарцуулснаас олсон орлогын үр дүнтэй зарцуулалт, түүнд хяналт тавих, төрийн албан хаагчийн хууль бус ажиллагааны улмаас төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн орчин, тогтолцоог хангалттай бүрдүүлээгүй, авлигын мэдээлэгчийг хамгаалах, нууцлах, урамшуулах хууль тогтоомжгүй байгаа нь цаашид авлигыг улам даамжуулах эрсдэлтэй байна.

Иймд шударга ёсыг хангах, нийтийн албан тушаалтны гэмт хэргийг бууруулах, төсвийн хөрөнгө болон нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах, хураан авсан хөрөнгийг нийгмийн сайн сайхны төлөө зарцуулах зорилгоор Авлигын эсрэг багц хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн А/41 тоот тушаалаар байгуулан ажиллаж, холбогдох хуулийн төслийг боловсрууллаа.

Ажлын хэсэг хуулийн төслийг боловсруулах явцад Авлигын эсрэг хууль тогтоомжид хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Хууль зүйн үндэсний хүрээлэнгээр, зарим шаардлагатай судалгааг судлаачдаар хийлгэж, гадаадын зарим улс орны хууль тогтоомжийг судалсан болно.

Түүнчлэн Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэгч гол байгууллагууд буюу Авлигатай тэмцэх газар, шүүх, прокурор, цагдаагийн байгууллага, төрийн аудитын байгууллагаас холбогдох мэдээллийг авч, хэрэгжүүлэгч байгууллагын төлөөлөлтэй хуулийн төсөл боловсруулах явцад уулзалт, ярилцлага хийх байдлаар асуудлыг тодруулан ажилласан.

Ажлын хэсгийн хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 14.4-т “Хууль санаачлагч тодорхой салбарын хоорондоо уялдаатай хэд хэдэн хуулийн төслийг нэгэн зэрэг хамтад нь хэлэлцүүлэхээр багцлан боловсруулж, өргөн мэдуулж болно.” гэж, 14.5-т “Энэ хуулийн 14.4-т заасны дагуу хэд хэдэн хуулийн төслийг багцлан боловсруулахаа тухайн харилцааг зохицуулж байгаа ерөнхий хуулийг дагаж анхдагч хуулийн төсөл боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд төсөл тус бүрийн агуулгыг нэгтгэн нэг үзэл баримтлалаар тодорхойлж болно.” гэж тус тус заасны дагуу Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай анхдагч хуулийн төсөл болон түүнийг дагалдуулан холбогдох хуулийн төслүүдийг багцлан боловсрууллаа.

Дагалдуулан боловсруулсан хуулийн төсөлд Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай анхдагч хуулийн төсөл, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Прокурорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах

тухай, Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай гэсэн нийт 18 дагалдах хуулийн төсөл багтаж байгаа болно.

Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг иргэний журмаар нэхэмжлэх, нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалт нь нийгмийн шударга ёсыг хангахад онцгой ач холбогдолтой бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар авлигын эсрэг хууль тогтоомж боловсронгуй, тодорхой болж, нийгэм, эдийн засаг, хууль зүйн олон эерэг үр дүн үзүүлнэ.

Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэхээр Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.2-т заасны дагуу тус яамны албан ёсны цахим хуудсанд 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр байршуулсан бөгөөд хуулийн төслийг олон нийтэд танилцуулах хэлэлцүүлгийг иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, төрийн байгууллага, ялангуяа шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагч, хуульч эрдэмтэн, судлаач гэсэн 2 хүрээнд 2025 оны 1 дүгээр сарын 10, 14-ны өдрүүдэд зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт нийт 150 гаруй хүн оролцож саналаа илэрхийлсэн ба үүнд иргэд, төрийн бус байгууллагын төлөөллөөс хуулийн төслийг яаралтай батлуулах, хууль батлагдсаны дараа хуулийн хэрэгжилтэд анхаарах, хэрэгжүүлэх байгууллагын тогтолцоог тодруулах, шинэчлэх, хуулиа сурталчлах, хууль хэрэгжилтэд гарч болзошгүй асуудлын талаар асуулга ирүүлсэн ба шаардлагатай саналуудыг хуулийн төсөлд тусгасан болно.

Хуулийн төслийг 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр холбогдох төрийн байгууллагуудаас санал авахаар Улсын Дээд Шүүх, Хүний эрхийн Үндэсний комисс, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, төрийн захиргааны төв байгууллагууд, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар зэрэг нийт 44 байгууллагад хүргүүлсэн. Энэ хүрээнд 2025 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар Улсын Дээд Шүүх, Хүний эрхийн Үндэсний комисс, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, төрийн захиргааны төв байгууллагууд, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар зэрэг нийт 26 байгууллагаас санал ирүүлээд байна.

Дээрх байгууллагуудаас ирүүлсэн саналыг судлан ажиллаж, хуулийн төсөлд үндэслэлтэй саналуудыг тусгаж ажилласан болно.